

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тавантолгой ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2022/2/НА-СТА-ОНӨОААН

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Даланзадгад хот 2022 он</p>	<p>Өмнөговь аймаг дахь төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533539 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn</p> <p>Гэрээгээр гүйцэтгэсэн "Гэрэлт хөхийн тэнцвэр Аудит" ХХК-ийн захирал Д.Баатарсайхан Утас: 93099119 Цахим хаяг: Gerelthuhaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: omngovi@audit.gov.mn

2022.05.15 № 258  
талай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТАВАНТОЛГОЙ ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Ж.ДОРЖСҮРЭН ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тавантолгой ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Тавантолгой ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон зүйл**

Олон улсын зах зээлийн нүүрсний үнийн өсөлтөөс болж АМНАТ-ын төлбөр нь зарим саруудад огцом өссөн, АМНАТ-ын тухайн сарын төлбөрийг тооцохдоо дараа сарын эхэн дэх үнээс тооцож байгаа нь ашигт ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөөлж байна.

Онцгой нөхцөл байдалд тогтоосон журам зааврын улмаас хилийн бүс рүү нэвтэрч тус компанийн хилийн бүсэд бэлтгэсэн хөрөнгөнд биет горим хэрэгжүүлж, тооллого хийгдэх боломжгүй байсан.

**Аудитын гол асуудлууд**

Тус байгууллага нь 2,800.0 сая төгрөг төлбөрийн чадваргүй болсон Чингис хаан банканд байршуулсан байсныг 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 180/ШШ2021/02341 тоот Сүхбаатар дүүргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр Чингис хаан банкнаас гаргуулахаар шийдвэрлэсэн.

Засгийн газрын 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 185 тоот Чингэлэг тээврийн терминал байгуулах тухай тогтоолын хүрээнд ТУЗ-ын 2021 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 25 тоот тогтоолоор орон тооны дээд хязгаарыг 40, сарын зардлын дээд хязгаарыг 523.3 сая төгрөгөөр баталж ажилласан байна.

**Бусад асуудал**

"Ковид-19" цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах, өөрсдийн үндсэн үйл ажиллагааны явцад халдвараас сэргийлэх дэглэмийг сахиулахтай холбоотой ажлын байр орчмын бүсэд ариутгал хийж ажилласан.

016020401

Цар тахлын үеийн хөл хориотой холбоотой төлөвлөгөөт борлуулалт 71.7 хувиар буурсан байна.

**Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ энгид орох талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЦЭРЭНБАЯР

D:\2021 Он\Бичиг Хэрэг\Явсан Бичиг\2022-03-15 №258с

## Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мерийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө</b>	<b>95,945,674,714.39</b>	<b>78,689,047,068.65</b>
1.1.2	Дансны авлага	16,007,443,155.77	18,379,051,047.08
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	621,168,788.51	177,578,064.26
1.1.4	Бусад авлага	79,182,314.45	99,887,367.00
1.1.6	Бараа материал	7,826,361,587.13	37,471,813,343.80
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	1,935,969,937.00	2,247,122,850.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	18,940,000.00	25,980,000.00
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	1,053,686,450.00	1,053,686,450.00
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>123,488,426,947.25</b>	<b>138,144,166,190.79</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	14,502,686,054.67	14,781,291,329.77
1.2.2	Биет бус хөрөнгө	1,677,068,128.77	1,339,443,730.45
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	434,179,457.49	434,179,457.49
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>16,613,933,640.93</b>	<b>16,554,914,517.71</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>140,102,360,588.18</b>	<b>154,699,080,708.50</b>
2.1.1.1	Дансны өглөг	12,950,962,440.42	10,729,626,715.97
2.1.1.2	Цалингийн өглөг	128,981,563.42	197,358,744.66
2.1.1.3	Татварын өр	24,790,089,320.27	49,901,308,848.99
2.1.1.4	НДШ-ийн өглөг	0.00	26,448,918.87
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	11,990,129,567.44	658,515,350.94
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	14,154,285,093.69	32,853,524,416.50
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	198,300.00	991,400.00
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>64,014,646,285.24</b>	<b>94,367,774,395.93</b>
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	12,512,250.00	0.00
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>12,512,250.00</b>	<b>0.00</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>64,027,158,535.24</b>	<b>94,367,774,395.93</b>
2.3.1	Төрийн өмч	48,188,698.49	48,188,698.49
2.3.2	Хувийн өмч	46,298,945.60	46,298,945.60
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	511,036,236.35	468,414,309.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	75,469,678,172.50	59,768,404,359.48
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>76,075,202,052.94</b>	<b>60,331,306,312.57</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>140,102,360,588.18</b>	<b>154,699,080,708.50</b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	<b>254,181,245,115.76</b>	<b>179,329,481,753.71</b>
2	Борлуулалтын өртөг	210,357,174,609.39	155,305,775,852.43
3	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>43,824,070,506.37</b>	<b>24,023,705,901.28</b>
4	Хүүгийн орлого	1,391,463,613.50	838,130,066.71
5	Бусад орлого	292,453,856.62	258,793,368.13
6	Ерөнхий ба удирдлагын зардал	3,544,783,804.09	3,787,585,355.14
7	Бусад зардал	2,177,527,492.00	3,662,060,163.24
8	Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз )	1,195,941,594.27	-21,061,251.95
9	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )	-1,009,594,493.54	-100,789,705.69
10	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>39,972,023,781.13</b>	<b>17,549,132,860.10</b>
11	Орлогын татварын зардал	8,626,841,224.22	3,756,659,583.72
12	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>31,345,182,556.91</b>	<b>13,792,473,276.38</b>
13	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	<b>31,345,182,556.91</b>	<b>13,792,473,276.38</b>
14	<b>Орлогын нийт дүн</b>	<b>31,345,182,556.91</b>	<b>13,792,473,276.38</b>
15	<b>Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг ( алдагдал )</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	94,487,644.09	511,036,236.35	88,923,162,625.07	89,528,686,505.51
2	Залруулсан үлдэгдэл	94,487,644.09	511,036,236.35	88,923,162,625.07	89,528,686,505.51
3	Зарласан ногдол ашиг	-	-	43,238,129,200.00	43,238,129,200.00
4	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	31,345,182,556.91	31,345,182,556.91
5	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	94,487,644.09	511,036,236.35	75,469,678,172.50	76,075,202,052.94
6	Залруулсан үлдэгдэл	94,487,644.09	511,036,236.35	75,469,678,172.50	76,075,202,052.94
7	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	(1,317,865,089.40)	(1,317,865,089.40)
8	Зарласан ногдол ашиг	-	-	28,175,882,000.00	28,175,882,000.00
9	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	13,792,473,276.38	13,792,473,276.38
10	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(42,621,927.35)	-	(42,621,927.35)
11	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	94,487,644.09	468,414,309.00	59,768,404,359.48	60,331,306,312.57

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант үеийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>258,122,716,717.29</b>	<b>196,556,148,425.78</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	257,914,055,990.40	196,409,685,608.77
1.1.6	Бусад мөнгөн орлого	208,660,726.89	146,462,817.01
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>190,748,840,278.39</b>	<b>174,269,949,703.78</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	4,740,766,152.19	6,014,617,981.78
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,125,832,660.79	1,817,757,289.17
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	123,169,353,270.89	109,638,955,801.09
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	301,822,890.99	274,693,653.77
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	10,748,854.40	2,631,721,880.04
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	60,400,334,549.25	50,041,924,632.79
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	3,605,280.00	151,806,037.16
1.2.9	Бусад мөнгөн зарлага	996,376,619.88	3,698,472,427.98
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<b>67,373,876,438.90</b>	<b>22,286,198,722.00</b>
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,391,463,613.50	838,130,066.71
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	1,391,463,613.50	838,130,066.71
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	722,697,052.00	852,456,190.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	722,697,052.00	852,456,190.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<b>668,766,561.50</b>	<b>(14,326,123.29)</b>
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,371,094,585.73	29,637,902.80
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	1,371,094,585.73	29,637,902.80
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	30,872,781,497.27	39,558,138,147.25
3.2.4	Төлсөн ногдол ашиг	30,697,228,048.37	39,507,496,216.50
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	175,553,448.90	50,641,930.75
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<b>(29,501,686,911.54)</b>	<b>(39,528,500,244.45)</b>
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	38,540,956,088.86	(17,256,627,645.74)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	57,404,718,625.53	95,945,674,714.39
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	95,945,674,714.39	78,689,047,068.65